



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 242

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15.8 дугаар заалтыг үндэслэн, Монголын Мянганы сорилтын сангийн Эрүүл мэндийн төслийн буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалт, ашиглалтыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. “Монголын Мянганы сорилтын сангийн Эрүүл мэндийн төслийн буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах журам”-ыг 1 дүгээр, “Эм, эмнэлгийн хэрэгслийн захиалга, зарцуулалт, тайлагналтад хөтлөх маягтын загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн дарга (Ч. Мөнхдэлгэр), Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газрын дарга (Ш. Энхбат) нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД

Ч. ХҮРЭЛБААТАР



060760

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 292
тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**Монголын Мянганы сорилтын сангийн Эрүүл мэндийн
төслийн буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлэгдсэн
эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах журам**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Монголын Мянганы сорилтын сан (МММС)-ийн Эрүүл мэндийн төслийн буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авах, хадгалах, хувиарлах, түгээх, зарцуулалтыг тайлагнах, хяналт тавих асуудлыг “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Эрүүл мэндийн тухай”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулиуд, Эрүүл мэндийн сайдын 2011 оны “Хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжаар ирсэн эм, эмнэлгийн хэрэгслийг зохицуулах журам”-д нийцүүлэн зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Төслийн хүрээнд умайн хүзүү болон хөхний өмөн, артерийн даралт ихдэлт, чихрийн шижин хэв шинж-2 зэрэг зонхилон тохиолдох халдварт бус өвчнүүдийн эрт илрүүлгийн үзлэг эмчилгээний хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэнийг чанартай эм, эмнэлгийн хэрэгслээр хангана.

Хоёр. Эм, эмнэлгийн хэрэгслийг захиалах, хувиарлах

2.1. Эрүүл мэндийн яам, ММСС-ийн Эрүүл мэндийн төслөөс чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх эм ханган нийлүүлэгчийг тендер зарлан шалгаруулж, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээг байгуулна.

2.2. Эм ханган нийлүүлэх байгууллага нь эм, эмнэлгийн хэрэгслийг импортын лизенцийн дагуу татан авч, чанарын баталгаажилтыг хуулийн дагуу хийлгэж, татан авалт, хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн шатанд эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

2.3. ММСС-ийн Эрүүл мэндийн төслөөс нийлүүлэгдэж буй эм, эмнэлгийн хэрэгслийн гаднах хайрцаг, сав, баглаа боодол дээр “Америкийн нэгдсэн улсын ард түмний тусламж” гэсэн хаягийг наасан байна.

2.4. Аймаг, дүүргийн болон сум дундын эмнэлэг, өрх, тосгон, сумын эрүүл мэндийн төвүүд өдөр тутмын эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэглээний олголтын бүртгэл, зарлагын тайлан ба захиалгыг /маягт №7 ба 8/ үндэслэн сар, улирлын хэрэгцээг тогтоож, захиалгыг хийж, аймгийн Эрүүл мэндийн газар болон дүүргийн эрүүл мэндийн нэгдэл (Багахангай дүүргийн нэгдсэн эмнэлэг)-ээр дамжуулан нийслэлийн Эрүүл мэндийн газарт ирүүлнэ.

2.5. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь харъяа эмнэлгийн байгууллагаас ирүүлсэн зарцуулалтын тайлан, захиалгыг нэгтгэж /маягт №8 ба 9/ улирал бүр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар, хөтөлбөрийн зохицуулагчид ирүүлнэ.

2.6. Орон нутагт эм, эмнэлгийн хэрэгслийг нэгж, салбаруудад хуваарилах, хадгалах, түгээх, мэдээлэх, сурталчлах болон нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэнд хүргэх, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл зохион байгуулна.

2.7. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар, хөтөлбөрийн зохицуулагчтай хамтран эм, эмнэлгийн хэрэгслийн захиалга, судалгаа, нөөцийг үндэслэн аймаг, нийслэл, дүүрэгт хувиарлалтыг хийж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулна.

2.8. Аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар эм, эмнэлгийн хэрэгслийг харьяа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд хуваарилах асуудлыг шийдвэрлэнэ.

Гурав. Эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авах, хадгалах, түгээх

3.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, нэгдсэн эмнэлэгт эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалах, түгээх, бүртгэх үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар мэргэжлийн удирдлагаар хангана.

3.2. Аймаг, дүүрэг, сумын хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авах, хадгалах, түгээх ажлыг аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн болон сумын эмийн эргэлтийн сангийн эрхлэгчид хариуцан гүйцэтгэнэ.

3.3. Өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд төвийн ахлагч эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авах, хадгалах, түгээх ажлыг хариуцан гүйцэтгэх ажилтныг томилон гүйцэтгүүлнэ.

3.4. ММСС-ийн Эрүүл мэндийн төслөөс нийлүүлэгдэж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэнд оношлогоо, эмчилгээний заалтаар үнэ төлбөргүй олгоно.

3.5. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын эмийн асуудал хариуцсан мэргэжилтэн, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв болон сумын эмийн сангийн эрхлэгч, өрхийн эрүүл мэндийн төвийн ахлагч зэрэг итгэмжлэгдсэн ажилтнууд зарлагын баримт ба эм барааг дагалдах хуудас /маягт №2 ба 5/ чанарын баталгаажилтын бичиг зэргийг үндэслэн эм, эмнэлгийн хэрэгслийг гадаад байдлаар чанарыг үнэлэн /тунадасжсан, өнгө нь өөрчлөгдсөн, тээвэрлэлтийн дэглэм баримталсан г.м/ эм хүлээн авсан тухай актыг үйлдэн /маягт №3/ хувиарлагдсан эм барааг хүлээн авна.

3.6. Хүлээн авсан эм, эмнэлгийн хэрэгсэлд орлогын баримт /маягт №1/ үйлдэж, нийлүүлэгчээс хүлээн авснаас эцсийн хэрэглэгчид хүргэх хүртэл шаардлага хангасан нөхцөлд хадгалж, эм, хэрэгслийн нэр төрөл бүрээр агуулахын бүртгэл /маягт №4/-ийг хөтөлнө.

3.7. Эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалах агуулахын тавиурыг эм, барааг олгох, тоолох, ерөнхийд нь зохицуулах, эхэлж хугацаа дуусахыг эхэлж гаргах зарчмаар гаргахад хялбар байхаар байрлуулж, хадгалалтын дэглэмийг хянаж,

бүртгэл хөтөлнө. Эмийг хурааж өрөхдөө нэр, цуврал, үйлдвэрлэгч, хүчинтэй хугацааг нүдэнд ил харагдахаар байрлуулна.

3.8. Эм, эмнэлгийн хэрэгслийг ачих, тээвэрлэх хүмүүс нь тэдгээрийн шинж чанар, тээвэрлэх, хадгалах горимын талаар тодорхой мэдлэгтэй, ачиж, хүлээн авснаас хойш захиалагчид хүргэх хүртэл чанарыг алдагдуулахгүй байх асуудлыг хариуцах тул ханган нийлүүлэгч онцгой анхаарал хандуулсан байна.

3.9. Эм, эмнэлгийн хэрэгслийг тээвэрлэгч нь дагалдах хуудсыг хөтөлж /маягт №5/ хүлээн авах комисс буюу эрх бүхий албан тушаалтанд бичиг баримтын дагуу тулган шалгаж хүлээлгэн өгч, эм хүлээн авсан тухай актын нэг хувийг авч эм ханган нийлүүлэгчид өгнө.

3.10. Эрт илрүүлгийн үзлэгээр артерийн даралт ихсэлт, чихрийн шижин хэв шинж-2 оношлогдсон нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэнд эмч тохирох эмийн тун хэмжээ, тоо ширхэгийг заасан стандартын шаардлага хангасан жор бичиж, эмийн хэрэглэх арга, хугацаа, илрэх гаж нөлөө зэргийг үйлчлүүлэгчид тайлбарлана.

3.11. Аймаг, дүүрэг, сум, хорооноос олгогдсон нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэн мөн болохыг тодорхойлох “Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрхийн бичиг” дэвтэр, дэвтэр олгогдоогүй тохиолдолд хорооны даргын тодорхойлолт, эмчийн бичсэн жорын дагуу аймаг, дүүрэг, сумын эмийн сан, өрхийн эрүүл мэндийн төвөөс үйлчлүүлэгчдэд эмийг олгох ба эм олголтын бүртгэл /маягт №7/-д ямар нэрийн эмийг хичнээн тоо, хэмжээгээр олгосныг хөтлөнө.

3.12. ММСС-ийн Эрүүл мэндийн төслөөс нийлүүлэгдсэн Метформин эмийг уг өвчтөнд энэ эмийг олгох тухай Эмч нарын зөвлөгөөний шийдвэр, аймаг, дүүрэг, сум, хорооноос олгогдсон нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэн мөн болохыг тодорхойлсон тодорхойлолт, эмийн жорыг үндэслэн эмийн сангаас үйлчлүүлэгчдэд олгож, эм олголтын бүртгэл /маягт №7/-д эмийг хичнээн тоо, хэмжээгээр олгосныг хөтлөнө.

3.13. Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, Хавдар судлалын үндэсний төвд мэдээгүйжүүлэлтэнд хэрэглэх Бупивикайн, Лидокайн ба Адреналины тарилгын уусмал, эд эсийн шинжилгээнд хэрэглэгдэх будагч бодисууд, цахилгаан өөлөгч багажийн хошуу зэрэг бусад эмнэлгийн хэрэгслийг оношлогоо, эмчилгээний заалтаар хэрэглэж, эдгээрийг шууд гардан хэрэглэж буй сувилагч эм олголтын бүртгэл /маягт №7/-д хичнээн тоо, хэмжээгээр хэрэглэснийг тэмдэглэнэ. Энэхүү бүртгэлийг үндэслэн уг эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын тайланг сувилагч гаргаж эмийн санчид өгөх ба эмийн санч бусад эмийн зарцуулалтын тайлан, захиалгатай нэгтгэнэ.

Дөрөв. Эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтыг тайлагнах, хяналт тавих

4.1. Нөөцөд байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн тоо хэмжээ нь агуулахын бүртгэлийн үлдэгдэлтэй тохирч байгаа эсэхийг магадлах, агуулахын бүртгэл зөв хөтлөгдөж байгаа эсэх, гэмтэж муудсан, хагарсан, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслийг илрүүлэх зорилгоор жилдээ 2-оос доошгүй удаа тооллого явуулж, бүртгэлийг /маягт №6/ хөтлөнө.


4.2. Түгээгдэж буй эм, эмнэлгийн хэрэгслийн хүлээн авалт, тээвэрлэлт, хадгалалт, түгээлт, өвчтөнд хүрч буй байдал, бүртгэл хөтлөлт зэрэг нь хэр зөв явагдаж байгааг магадлах, төслийн зорилго, зарчмыг тайлбарлаж, дэмжих зорилгоор хяналт, үнэлгээг бүх шатны эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн газар, төслийн багийнхан улирал бүр хийж, үнэлгээний хуудсыг /маягт №10/ хөтлөнө.

4.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт үнэлгээний тайлангийн талаарх мэдээг төсөл хэрэгжүүлэх нэгжид хагас ба бүтэн жилээр ирүүлнэ.

4.4. Орон нутагт ММСС-ийн Эрүүл мэндийн төслийн хүрээнд нийлүүлэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтад аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар хяналт тавина.

4.5. Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газар, Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн газар нь хуваарилагдсан эм, эмнэлгийн хэрэгслийн орон нутгийн хуваарилалт, түгээлт, зарцуулалт, хэрэглээнд хяналт, үнэлгээ хийж, Удирдлагын зөвлөлд танилцуулна.

--- оОо ---



Эрүүл мэндийн сайдын 20... оны... маягт №1
 ТООТ ТУШААЛЫН ХОЁРДУГААР ХАВСГАЛТ

ОРЛОГЫН БАРИМТ №

20... оны...сарын...өдрөөс...р сарын ...ны өдрийн баримт
 Агуулах№ _____
 Байгууллагын нэр: _____
 Эд хариуцагч: _____

№	Огноо	Эмийн нэр, тун хэмжээ	Цуврал	Хэрэглэх хүчинтэй хугацаа	Үйлдвэрлэгчийн нэр	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Баталгаажилтын баримт бичиг
БҮГД ДҮН									

Тайлан гаргасан эд хариуцагч:
 Хянасан нягтлан бодогч:

маягт №2

ЗАРЛАГЫН БАРИМТ №

20... оны ...сарын ...өдрөөс...р сарын...ны өдрийн баримт
 Агуулах№ _____
 Байгууллагын нэр: _____
 Эд хариуцагч: _____

№	Огноо	Эмийн нэр, тун хэмжээ	Цуврал	Хэрэглэх хүчинтэй хугацаа	Үйлдвэрлэгчийн нэр	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Баталгаажилтын баримт бичиг
БҮГД ДҮН								

Тайлан гаргасан эд хариуцагч:
 Хянасан нягтлан бодогч:

ЭМ ХЭРЭГСЭЛ ХҮЛЭЭН АВСАН ТУХАЙ АКТ

Бараа нийлүүлэгч:

Хүлээн авагч:

Барааг дагалдах падааны дугаар:

Огноо:

№	Эм хэрэгсэлийн нэр, тун хэмжээ	Цуврал	Хэрэглэх хүчинтэй хугацаа	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Ирвэл зохих тоо	Ир-сэн тоо	Зөрүүл тоол		Бүгд үнэ	Чанарын баталгаажилтын баримт бичиг	Тээвэрлэлтийн шаардлага хангасан байдал
								илүү	дууу			

Хүлээн авсан комисс: гарын үсэг, албан тушаал....

АГУУЛАХЫН БҮРТГЭЛ

Эмийн нэр, тун, хэмжээ: _____

Хэмжих нэгж: _____

Нэгж үнэ: _____

Эд хариуцагчийн нэр: _____

№	Огноо	Баримтын дугаар	Байгууллагын нэрс	Тоо хэмжээ				Эмийн цувралын дугаар	Эмийн үйлдвэр лэгчийн нэр	Хүчинтэй хугацаа	Баталгаа жилтын баримт бичиг
				Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл				

Бүртгэл хөтөлсөн мэргэжилтэн: _____
 Хянасан нягтлан бодогч: _____

ЭМ БАРААГ ДАГАЛДАХ ХУУДАС

Бараа нийлүүлэгч
Хүлээн авагчийн нэр:
Огноо:

№	Эм хэрэгсэлийн нэр, тун хэмжээ	Тоо ширхэг	Тээвэрлэлтийн үед баримтлах журам	Тээвэрлэлтийн байдал

Бэлтгэгчийн нэр:
Тээвэрлэгчийн нэр:

ЭМ ХЭРЭГСЛИЙН ТООЛЛОГЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр:

Байршил:

Огноо

Хөтөлбөрийн нэр:

маягт №6

№	Эм хэрэгсэлийн нэр, тун хэмжээ	Цуврал	Хэрэглэх хүчинтэй хугацаа	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Бүртгэлээр		Тооллогоор		Илүү		Дутуу		Тусгай тэмдэглэл
						Тоо	Бүгд үнэ	Тоо	Бүгд үнэ	Тоо	Бүгд үнэ	Тоо	Бүгд үнэ	

Тооллогын комисс: \гарын үсэг, албан тушаал\....

Эд хариуцагч:

ЭМ,ХЭРЭГСЛИЙН ОЛГОЛТЫН БҮРТГЭЛ

Эмийн нэр, тун хэмжээ

Хот, дүүрэг:

Аймаг, сум, өрх, баг:

Үйлчилгээ үзүүлэгчийн нэр:

Огноо:

№	Овог нэр	Нас	Реги-стр	Боловс рол	Хаяг	Эмийн жор	Эмийг бичсэн эмчийн нэр	Удирд-лагын шийд-вэр	Өвчний түүх, картын дугаар	Хэрэглэгч		Олго-сон тоо ширхэг	Цув-рал	Үйлд-вэр лэгч	Хүлээж авсан хүний гарын үсэг
										анх	дав-тан				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16

Монголын мянганы сорилтын сангийн эрүүл мэндийн төслөөс олгосон эмийг хэрэглэгчдэд үнэ төлбөргүй олгосон тохиолдолд энэ бүртгэлийг хөтөлнө.

Эмийн нэр төрөл бүрээр бүртгэлийг хөтөлнө.

: РЛАГЫН ТАЙЛАН БА ЗАХИАЛГА

Аймаг, хот /Сум, дүүрэг/:

Байгууллагын нэр:

Тайлан ба захиалга өгсөн огноо:

№	Эм хэрэгсэлийн нэр, тун, хэмжээ	Хэмжих нэгж	Зарлагын тайлан						Захиалга			
			Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Хэдэн хүнд олгогдсон	Хорогдол	Эцсийн үлдэгдэл	Захиалах тоо	Эмийн жинхэнэ олгосон тоо, хэмжээ		

Хянасан:

Аймаг, нийслэл, дүүрэг, өрх, тосгоны эмнэлгийн /дарга/ ерөнхий эмч: Гарын үсэг,тамга:
Тайлан гаргаж, захиалга хийсэн:.....

ЭМИЙН ЗАХИАЛГЫН НЭГТГЭЛИЙН МАЯГТ

Нэгтгэлийн маягт №9-г аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын ба эм хангамж компанийн мэргэжилтэн хөтөлж, албан ёсоор даргаар хянуулж, баталгаажуулан хагас, бүтэн жилээр хөтөлбөрийн зохицуулагчид ирүүлсэн байна.

Аймаг хотын нэр:

20.....оны эмийн захиалгын нэгтгэл:

Огноо:

Хянасан:

Аймаг, нийслэлийн ЭМГ-ын дарга: Гарын үсэг,тамга:

№	Эм хэрэгсэлийн нэр, тун хэмжээ	Хэмжих нэгж	Айм.дүүргийн нэгд эмнэлэг	Сум										Өрх			Нийт тоо ширхэг	Бүгд үнэ				

Захиалга нэгтгэсэн:

Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн:

ЭХК-ний мэргэжилтэн:

Байгууллагын үйл ажиллагааг шалгах хуудас

Дотоодын хяналтын хуудас:

№		Тийм	Үгүй
Баримт хөтлөлт:			
1	Бүртгэлүүдийг хугацаанд нь бүртгэдэг /хэдийд хамгийн сүүлд бүртгэснийг шалгах/		
2	Бүртгэлүүдийг алдаагүй, зөв бүртгэдэг		
3	Хэрэглэгчдэд олгосон эм, хэрэгслийн тоо хэмжээг бүртгэлд бүрэн тусгасан		
4	Ажиллагсад хангамжийн талаарх зааварчлага, материалаар бүрэн хангагдсан		
Нөөц:			
1	Агуулахын бүртгэл дэх тоо нь тооллогоор тоологдсон тоотой тохирч байна		
2	Сарын дундаж хэрэглээг тооцоолон гаргасан		
3	Эм хэрэгсэл байвал зохих хэрэгцээний доод болон дээд хязгаарын дундаж түвшинд байна		
4	Эм, хэрэгсэл тасраагүй нөөцтэй байна		
Чанарын баталгаа:			
1	Эмийн чанарыг баталгаажуулсан баримттай		
2	Эм, хэрэгслийн чанарыг шалгах тогтолцоотой /байгаа бол тодруулах/		
3	Эм хүлээн авах үед эмийн гадна байдлын чанарын хяналтыг гүйцэтгэж, акт үйлдсэн		
4	Эмийн тээвэрлэлт зөв хийгдсэн		
5	Хэрэглэгчдэд хүргэхийн өмнө эмийн чанарыг шалгадаг		
6	Чанарын баталгаатай холбоотой бүртгэл хөтөлдөг		
7	Хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, гэмтсэн, чанарын шаардлага хангаагүй эмийг зохих журмын дагуу устгасан		
Шаардлагатай өвчтөнд хүрч байгаа:			
1	Зөвхөн эмзэг бүлгийн хүмүүст хүрдэг		
2	Умайн хүзүүний өмөн, артерийн даралт ихдэлт, чихрийн шижин хэв шинж 2 зэрэг оноштой өвчтөнд л эмийн жор бичигдэж, олгогддог ба хэрэглэгддэг		
3	Эмчилгээний удирдамжид заасан тоо хэмжээгээр олгогддог		
Захиалга: тайлагналт			
1	Эмийн хэрэгцээний доод болон дээд хязгаарыг дундаж түвшинд байлгах үүднээс захиалгыг цагт нь гүйцэтгэдэг		
2	Захиалгыг зөв тооцдог		
3	Сүүлийн 6 сарын хугацаан дах тайлан бүрэн, зөв хийгдсэн		
4	Тайлан, мэдээг зохих газар нь хугацаанд нь хүргүүлдэг		
Агуулахын /хадгалах/ нөхцөл			
1	Цэвэр Уужим Эм хадгалах тавиур хүрэлцээтэй Шаардлага хангасан зай талбайтай		
2	Дохиоллын систем, манаачтай Шал ханыг цэвэрлэхэд хялбар гөлгөр		

	Ахуйн мэрэгч шавьжнаас хамгаалагдсан Хувцас солих болон ариун цэврийн өрөөтэй Гэрэлтүүлэг шаардлага хангасан Агааржуулалт шаардлага хангасан		
3	Агаарын хэм, чийгшилтийг хянадаг		
4	Хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан, гэмтсэн, чанарын шаардлага хангаагүй эмийг тусгайд нь хадгалдаг		
5	Эмийг эхэлж хугацаа дуусахыг эхэлж гаргах зарчмыг баримтлан түгээдэг		
6	Нарны гэрлээс хамгаалагдсан нөхцөлд эмийг хадгалдаг		
7	Агуулахаас эмийг хэрэгцээтэй үед авах боломжтой		